**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/93/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Ч.Мөнхбаяр<br>Утас: 89275858<br>Цахим хаяг: tsesb.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын тудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 112

танай ______________-ны №______________-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ
СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАТБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 26,360.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 120,309.1 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, 128,084.4 мянган төгрөгийн сурагчийн ширээ, сандал, Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 200,091.7 мянган төгрөгийн гадна шугам, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 8,687.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Нийгмийн хариуцлагын хүрээнд "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн хөрөнгө оруулалтаар 99,608.8 мянган төгрөгийн бараа материал, компьютер, спортын тоног төхөөрөмжүүдийг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050143

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 3,102,925.4 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 23.0 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 163 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.3 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР



3

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **438,828,924.28** | **347,133,189.28** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **291,539,003.11** | **129,239,114.61** |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 291,539,003.11 | 129,239,114.61 |
| 3121 | төгрөг | 291,539,003.11 | 129,239,114.61 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 291,539,003.11 | 129,239,114.61 |
| **33** | **АВЛАГА** | **-** | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **147,289,921.17** | **217,894,074.67** |
| **351** | **Түүхий эд материал** | **1,242,430.00** | **1,275,500.00** |
| 3513 | Эм боох материал | 1,242,430.00 | 1,275,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **146,047,491.17** | **216,618,574.67** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,700,360.00 | 3,950,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 102,022,139.17 | 156,509,959.17 |
| 3545 | Барилгын засварын материал | 4,554,800.00 | 6,914,900.00 |
| 3546 | Хүнсний материал | 3,608,436.00 | 16,761,455.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33,161,756.00 | 32,481,660.50 |
| 36 | НӨӨЦ БАРАА | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,148,708,411.36** | **6,284,763,578.71** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **6,148,708,411.36** | **6,284,763,578.71** |
| **392** | **Биет хөрөнгө** | **6,086,920,002.51** | **6,224,894,434.62** |
| 39201 | Барилга, байгууламж орон сууц | 6,475,364,113.13 | 6,636,687,322.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,156,838,346.08) | (1,331,895,852.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 683,975,651.26 | 857,675,796.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (182,621,855.77) | (309,190,075.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 236,983,630.98 | 354,791,951.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (88,276,407.50) | (83,769,081.61) |
| 39209 | Зам гүүрийн байгууламж | 87,109,727.21 | 87,109,727.21 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (32,188,800.24) | (37,553,600.14) |
| 39217 | Ном | 63,412,289.52 | 51,038,246.50 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **61,788,408.85** | **59,869,144.09** |
| 39301 | Программ хангамж | 13,109,358.00 | 13,109,358.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,432,949.15) | (10,352,213.91) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 57,112,000.00 | 57,112,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,587,537,335.64** | **6,631,896,767.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,587,537,335.64** | **6,631,896,767.99** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 6,587,537,335.64 | 6,631,896,767.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 946,771,565.43 | 946,771,565.43 |
| 51101 | Өмч: - төрийн | 946,771,565.43 | 946,771,565.43 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 575,445,630.53 | 619,805,062.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 575,445,630.53 | 575,445,630.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 44,359,432.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,065,320,139.68 | 5,065,320,139.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,587,537,335.64** | **6,631,896,767.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,995,073,949.22** | **5,070,231,582.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **366,888,649.22** | **673,794,182.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **366,888,649.22** | **673,794,182.50** |
| **120004** | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 27,793,740.00 | 9,195,070.00 |
| **1200041** | Үндсэн үйл ажиллагааны орлогооос санхүүжих | 6,434,600.00 | |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогооос санхүүжих | 21,359,140.00 | 9,195,070.00 |
| **1200045** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 75,797,343.02 | 33,122,280.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 159,164,129.20 | 507,235,137.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 104,133,437.00 | 124,241,695.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,628,185,300.00** | **4,396,437,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,208,025,300.00** | **3,783,749,300.00** |
| **131001** | **Урсгалт үйл ажилгааны санхүүжилт** | 3,208,025,300.00 | 3,783,749,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **420,160,000.00** | **612,688,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 420,160,000.00 | 612,688,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,075,727,137.70** | **4,984,052,003.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,075,727,137.70** | **4,984,052,003.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,889,894,479.99** | **4,778,943,033.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,521,713,328.26** | **3,102,925,437.45** |
| 210101 | Үндсэн цалин | 1,573,694,098.92 | 1,854,611,247.82 |
| 210102 | Нэмэгдэл | 827,040,149.34 | 1,025,498,768.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 82,735,000.00 |
| 210104 | Урамшуулал | 120,979,080.00 | 140,080,421.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **314,500,932.22** | **383,465,998.68** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 217,486,721.43 | 264,312,730.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,594,107.71 | 31,326,522.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,433,592.35 | 16,407,923.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,595,657.53 | 14,283,764.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,390,853.20 | 57,135,057.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **399,614,782.29** | **597,708,434.94** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,131,131.79 | 22,338,734.08 |
| 210302 | Түлш, халаалт | 343,254,466.60 | 502,662,568.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 39,229,183.90 | 72,707,131.98 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,783,890.00** | **40,782,386.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,142,810.00 | 4,788,740.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 1,445,600.00 | 2,135,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 431,200.00 | 362,396.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,082,000.00 | 640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,440,246.00 | 10,744,544.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 12,242,034.00 | 22,111,206.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **36,176,338.00** | **47,443,716.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,191,481.00 | 830,330.00 |
| 210502 | Хоол хүнс | 34,984,857.00 | 46,613,386.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **128,457,600.00** | **79,593,681.00** |
| 210601 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 128,457,600.00 | 79,593,681.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **495,700.00** | **669,220.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 495,700.00 | 669,220.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **34,573,501.04** | **43,419,676.37** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,992,100.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,314,000.00 | 1,314,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,267,401.04 | 42,105,676.37 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **419,578,408.18** | **482,934,483.44** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,394,640.00 | 36,955,590.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,529,690.00 | 13,318,290.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 354,654,078.18 | 432,660,603.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **185,832,657.71** | **205,108,970.06** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **183,256,100.00** | **205,098,535.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 135,679,500.00 | 176,510,035.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 47,576,600.00 | 28,588,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **2,576,557.71** | **10,435.06** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,576,557.71 | 10,435.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(80,653,188.48)** | **86,179,578.56** |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 41,820,146.21 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 41,820,146.21 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | | (41,820,146.21) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(80,653,188.48)** | **44,359,432.35** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | ***ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ*** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,996,891,640.00** | **4,405,632,470.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,793,740.00** | **9,195,070.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **8,793,740.00** | **9,195,070.00** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | **8,793,740.00** | **9,195,070.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,434,600.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,359,140.00 | 9,195,070.00 |
| **13** | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,988,097,900.00** | **4,396,437,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,567,937,900.00** | **3,783,749,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,567,937,900.00 | 3,783,749,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **-** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **420,160,000.00** | **612,688,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 420,160,000.00 | 612,688,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **0.00** | **0.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,618,461,253.52** | **4,497,753,858.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,618,461,253.52** | **4,497,753,858.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,432,628,598.81** | **4,282,443,643.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **2,521,713,328.26** | **3,102,925,437.45** |
| 210101 | Үндсэн цалин | 1,573,694,098.92 | 1,854,611,247.82 |
| 210102 | Нэмэгдэл | 827,040,149.34 | 1,025,498,768.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 82,735,000.00 |
| 210104 | Урамшуулал | 120,979,080.00 | 140,080,421.08 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **314,500,932.22** | **383,465,998.68** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 217,486,721.43 | 264,312,730.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 25,594,107.71 | 31,326,522.27 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 13,433,592.35 | 16,407,923.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 11,595,657.53 | 14,283,764.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 46,390,853.20 | 57,135,057.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **399,614,782.29** | **597,708,434.94** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,131,131.79 | 22,338,734.08 |
| 210302 | Түлш, халаалт | 343,254,466.60 | 502,662,568.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 39,229,183.90 | 72,707,131.98 |
| 210304 | байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материал** | **-** | **-** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | **32,851,135.00** | **49,565,160.00** |
| 210502 | Хоол хүнс | 32,851,135.00 | 49,565,160.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил урсгал засвар** | **20,327,800.00** | **16,864,300.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 20,327,800.00 | 16,864,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **-** |
| 210702 | Дотоодын томилолт | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,702,001.04** | **42,322,676.37** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,434,600.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,267,401.04 | 42,322,676.37 |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **106,918,620.00** | **89,591,636.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,353,620.00 | 71,806,536.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,565,000.00 | 17,785,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **185,832,654.71** | **215,310,215.06** |
| **2131** | Бусад урсгал шилжүүлэг | **2,576,556.71** | **10,435.06** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | |
| 213102 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **2,576,556.71** | **10,435.06** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,576,556.71 | 10,435.06 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **183,256,098.00** | **215,299,780.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 135,679,499.00 | 186,711,280.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 47,576,599.00 | 28,588,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг** | **-** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | . |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| **3** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(621,569,613.52)** | **(92,121,388.50)** |
| 4 | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | | |
| 5 | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн | **99,384,000.00** | **70,178,500.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 65,371,200.00 | 66,628,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 34,012,800.00 | 3,550,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| 6 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (99,384,000.00) | (70,178,500.00) |
| 8 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (720,953,613.52) | (162,299,888.50) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 87,506,464.47 | 291,539,003.11 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 291,539,003.11 | 129,239,114.61 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **946,771,565.43** | **5,065,320,139.68** | **656,098,819.01** | - | **6,668,190,524.12** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | **-** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | - | **-** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | **-** |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | **-** |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | **-** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (80,653,188.48) | | **(80,653,188.48)** |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **946,771,565.43** | **5,065,320,139.68** | **575,445,630.53** | **-** | **6,587,537,335.64** |
| D01 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | **-** |
| D02 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | - | **-** |
| D03 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | **-** |
| D04 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | **-** |
| D05 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | **-** |
| D06 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | **-** |
| D07 | Тайлант үеийн үр дүн | | | 44,359,432.35 | | **44,359,432.35** |
| D08 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **946,771,565.43** | **5,065,320,139.68** | **619,805,062.88** | **-** | **6,631,896,767.99** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **4,771,751,146.00** | **4,567,921,923.44** | **(203,829,222.56)** | **95.7%** |
| 21 | Урсгал зардлын дүн | 4,771,751,146.00 | 4,497,743,423.44 | (274,007,722.56) | 94.3% |
| **210** | **Бараа үйлчилгээний зардал** | **4,543,858,246.00** | **4,282,443,643.44** | **(261,414,602.56)** | **94.2%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,195,423,000.00** | **3,102,925,437.45** | **(92,497,562.55)** | **97.1%** |
| 210101 | Үндсэн цалин | 1,977,851,100.00 | 1,854,611,247.82 | (123,239,852.18) | 93.8% |
| 210102 | Нэмэгдэл | 1,099,791,300.00 | 1,025,498,768.55 | (74,292,531.45) | 93.2% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 82,735,000.00 | 82,735,000.00 | 0.0% |
| 210104 | Урамшуулал | 117,780,600.00 | 140,080,421.08 | 22,299,821.08 | 118.9% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | - | - | 0.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **399,427,800.00** | **383,465,998.68** | **(15,961,801.32)** | **96.0%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 271,610,900.00 | 264,312,730.86 | (7,298,169.14) | 97.3% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,954,200.00 | 31,326,522.27 | (627,677.73) | 98.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,977,100.00 | 16,407,923.19 | 430,823.19 | 102.7% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,977,100.00 | 14,283,764.54 | (1,693,335.46) | 89.4% |
| 210205 | ЭМД-ын хураамж | 63,908,500.00 | 57,135,057.82 | (6,773,442.18) | 89.4% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **649,628,500.00** | **597,708,434.94** | **(51,920,065.06)** | **92.0%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 27,803,800.00 | 22,338,734.08 | (5,465,065.92) | 80.3% |
| 210302 | Түлш, халаалт | 531,224,900.00 | 502,662,568.88 | (28,562,331.12) | 94.6% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 90,599,800.00 | 72,707,131.98 | (17,892,668.02) | 80.3% |
| 210304 | байрны түрээс | | - | - | 0.0% |
| **2105** | **Нормативт зардал** | **61,353,700.00** | **49,565,160.00** | **(11,788,540.00)** | **80.8%** |
| 210501 | Эм | - | - | - | 0.0% |
| 210502 | Хоол хүнс | 61,353,700.00 | 49,565,160.00 | (11,788,540.00) | 80.8% |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | - | - | - | 0.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **16,869,300.00** | **16,864,300.00** | **(5,000.00)** | **100.0%** |
| 210604 | Урсгал засвар | 16,869,300.00 | 16,864,300.00 | (5,000.00) | 100.0% |
| 2107 | Томилолт, зочны зардал | **-** | - | - | 0.0% |
| 210702 | Дотоод томилолт | - | - | - | 0.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр** | **59,521,646.00** | **42,322,676.37** | **(17,198,969.63)** | **71.1%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 550,900.00 | - | (550,900.00) | 0.0% |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 58,970,700.00 | 42,322,676.37 | (16,648,023.63) | 71.8% |
| 210807 | Газрын төлбөр | - | - | - | 0.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **161,634,300.00** | **89,591,636.00** | **(72,042,664.00)** | **55.4%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,849,200.00 | 71,806,536.00 | (72,042,664.00) | 49.9% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,785,100.00 | 17,785,100.00 | - | 100.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **227,892,900.00** | **215,299,780.00** | **(12,593,120.00)** | **94.5%** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** | **-** | **0.0%** |
| 213101 | Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг | - | - | **-** | **0.0%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **227,892,900.00** | **215,299,780.00** | **(12,593,120.00)** | **94.5%** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 199,304,400.00 | 186,711,280.00 | (12,593,120.00) | 93.7% |
| 213208 | хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | - | 0.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 28,588,500.00 | 28,588,500.00 | - | 100.0% |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | **-** | - | 0.0% |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **70,178,500.00** | **70,178,500.00** | **0.0%** |
| | Дотоод эх үүсвэрээр | | | - | 0.0% |
| | Тоног төхөөрөмж | | 66,628,500.00 | 66,628,500.00 | 0.0% |
| | Бусад хөрөнгө | | 3,550,000.00 | 3,550,000.00 | 0.0% |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **4,771,751,100.00** | **4,405,622,034.94** | **(366,129,065.06)** | **92.3%** |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | **3,809,353,700.00** | **3,783,749,300.00** | **(25,604,400.00)** | **99.3%** |
| 131001 | Улсын төсвөөс | 3,809,353,700.00 | 3,783,749,300.00 | (25,604,400.00) | 99.3% |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | | 0.0% |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | **-** | 0.0% |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | **664,770,700.00** | **612,677,664.94** | **(52,093,035.06)** | **92.2%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 664,770,700.00 | 612,677,664.94 | (52,093,035.06) | 92.2% |
| **1340** | | | | | |
| 120004 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | **297,626,700.00** | **9,195,070.00** | **(288,431,630.00)** | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 550,900.00 | | **(550,900.00)** | 0.0% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,027,100.00 | 9,195,070.00 | **167,970.00** | 101.9% |
| | | | | | |
| | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 288,048,700.00 | | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 291,539,003.11 | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 129,239,114.61 | | |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| 3 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| 4 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 115.00 | 105.00 | (10.00) | 91.3% |
| 5 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| 6 | Гүйцэтгэх ажилтан | 85.00 | 75.00 | (10.00) | 88.2% |
| 7 | Үйлчлэх ажилтан | 29.00 | 29.00 | - | 100.0% |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,500.0 мянган төгрөгийн алдаа[1] илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус сургуулийн хөрөнгөнд тооллого хийхэд Боловсролын газрын хөрөнгө оруулалтаар 63 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэл нийлүүлснийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас 40,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан тусгагдаагүй хөрөнгийг бүртгэсэн байна.

Аудитаар нийт 4,912.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэн тул 331.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,581.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Тайлант онд тус сургуулийн нярав Ц.Сувдмаад Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ”өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул 331.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь  төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т "*Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай",* "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

### 5.3.1 Цалин хөлс, урамшилтай холбоотой асуудал

*5.3.1 Илрүүлэлт*

Тайлант онд цалин хөлс, урамшилыг тооцохдоо цалингийн нэмэгдлийн зөрүү хэсэгт хоолны мөнгө болон цалин дүнгийг бууруулах зорилгоор хасах дүнтэй 2,560.0 мянган төгрөгөөр тавьж тооцоолсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар

---

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

зүйлийн 6.3.2-д "*Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасныг баримтлан, цалин хөлс, урамшилыг үнэн зөв тооцоолж ажиллах

### 5.3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

*5.3.2 Илрүүлэлт*

Тус сургуулийн хүнсний материалд тооллого хийхэд CTS санхүүгийн программд хүнсний материалын зарлагын гүйлгээг цаг тухай бүр хийдэггүй улмаас 956.0 мянган төгрөгийн зөрүү үүссэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "*Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасныг баримтлан, бараа материалыг цаг тухайд бүртгэж зарцуулж ажиллах

*1.3 Илрүүлэлт*

2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд татварын цахим системд үүссэн татварын өр төлбөрийн нэхэмжлэлийг тусгаж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",* 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1,20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг хэрэгжүүлэн, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

Тайлангийн 5.2, 5.3 дах хэсэгт дурдсан албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн

20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус сургуулийн хөрөнгөнд тооллого хийхэд БГ-ын хөрөнгө оруулалтаар Чиглэл ХХК-наас 2025.06.17 болон 2025.06.20-ны өдөр нийлүүлсэн 63 нэр төрлийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, багаж хэрэгсэлийг эрх бүхий байгууллагаас шийдвэр ирээгүй нь улмаас хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. | 1 | 40,500.0 | 1 | 40,500.0 | - | - | 1 | 40,500.0 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **40,500.0** | **1** | **40,500.0** | **-** | **-** | **1** | **40,500.0** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд няравт балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна. | 1 | 331.5 | - | - | 1 | 331.5 | **-** | **-** | - | - | - | - |
| Цалин хөлсийг тооцоолохдоо нэмэгдлийн цалингийн зөрүү хэсэгт хоолны мөнгө эсвэл цалингийн дунг бууруулан (хасах) дүнгээр тооцож бодсон нь байна. | 1 | 2,560.0 | - | - | **-** | **-** | 1 | 2,560.0 | - | - | - | - |
| Тус сургуулийн хүнсний материалд тооллого хийхэд санхүүгийн программд цаг тухай бүрд зарлагын гүйлгээг бүртгээгүйн улмаас 956.0 мянган төгрөгөөр зөрүү үүссэн байна. | 1 | 956.0 | | | | | 1 | 956.0 | | | | |
| 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд татварын цахим системд үүссэн татварын өр төлбөрийн 1,0645.4 мянган төгрөгийн нэхэмжлэлийг тусгаагүй байна. | 1 | 1,065.4 | | | | | 1 | 1,065.4 | | | | |
| **Дүн** | **4** | **4,912.9** | **-** | **-** | **1** | **331.5** | **3** | **4,581.4** | - | **-** | **-** | **-** |